

Гадаад харилцаа



ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт болсон хайр халамж хүмүүнлэгийн арга хэмжээнд Байгаль эх дэлхийгээ аварч тэнгэрлэг аян ТББ тэргүүн Д.Наранцогт нь оролцуулах арга хэмжээ авч Соёлын төвийн эрхлэгч, ардын авьяастан Л.Сарангэрэл нарыг үйл ажиллагаанд урин оролцуулж арга хэмжээний зардлыг даан ажилласан. Соёлын төвийн эрхлэгч Т.Мөнхцэцэг нь хүмүүлэгийн сайн үйлсийн үйл ажиллагаанд мэндчилгээ дэвшүүлэн, амжилт хүсч, ӨМӨЗО ТББ байгууллагын Хайр халамжийн холбооний тэргүүн 9 хүнд дурсгалын зүйл гардуулж, хамтран ажиллах санал хүсэлт гарган дурсамжийн зураг авахуулсан. Ардын авьяастан нар нь ая дуугаа өргөв. Тус арга хэмжээн дээр ардын авьяастан Л.Сарангэрэл нь МЭХ –ны хүндэт тэмдгээр шагнагдав.



5-р сарын 18 ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Тулга хайр халамжийн ТББ тэргүүн Түмэн гэрэл, Ордос аймгийн бие төлөөний нийт 11 өвөр монгол хүмүүс орон нутагт зочилж.



Соёлын төв нь дугуйлангийн сурагчдынхаа уран бүтээлийн дээжээс Талархалын тоглолтыг зохион байгуулан ажиллаа. Байгаль эх дэлхийгээ аварч тэнгэрлэг аян ТББ тэргүүн Д.Наранцогт нь ШИЛИЙН ГОЛ аймагт болох Хүүхдийн урлагийн наадам, багш нарын түршлага солилцох арга хэмжээнд Соёлын төвийн эрхлэгч, шавь нарын хамт оролцох боломжийг олгон “Бөмбөрцөгөө хайрлая” соёлын солилцоо арга хэмжээнд амжилттай оролцлоо. Тус арга хэмжээний үеэр 5 авьяаслаг сурагчидад Өвөр монгол залуу

Хөгжилт үр чадварыг үнэлэн сар бүр 100 юаний тэтгэлэг олгож, хувцаслаж урам хайрлан ажиллаж байна.

Тэнгэрлэг сайхан 8 ээжүүдийг алдаршуулах ажлыг зохион байгуулав. Буянтай ээжээр 89 настай 1-р багийн Даваа, Элбэрэлт ээжээр 89 настай 1-р багийн Дашдаваа, Бүтээлч ээжээр 2-р багийн 87 настай Д.Цэрэнбалам, Ачлалт ээжээр 85 настай Д.Маам, Асралт ээжээр 2-р багийн Н.Александр, Жаргалант ээжээр 2-р багийн Ц.Ишгэн, Оюунлаг ээжээр ахмад багш А.Энэбиш, Авьяаслаг ээжээр МУ-ын



ТАА Л.Сарангэрэл нарыг тодруулан өргөмжилж алдаршуулсан. Тус үйл

ажиллагаанд 60-89 настай ахмад бүүрай ээжүүд хамрагдсан. Үйл ажиллагаагаа Улсын Аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилагдав.

Улаан баатар хотын Royal цэнгээнт бүжгийн багш нар орон нутгийн иргэдийн урилгаар



Улаанбаатар хотийн Royal цэнгээнт бүжгийн сургалтын багш нарыг орон нутагт урьж эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн, заавал сурах 16 бүжгийг сурах анхан шатны 10 хоногийн сургалтыг зохион байгуулж иргэд, төрийн албан хаагч нийт 28 хүн хамрагдлаа. Тус сургалтаар ёохор, хүмүүн төрлөхтөн, задгай цагаан, жаахан дулмаа, Вальсвостон, Танго, покстрол гэх мэт 8 бүжгийг сурсан. Сургалтын явц үйл ажиллагааны Аз жаргалаа хуваалья, Шавиараа бахархая гэсэн сэдэвт тайлант үдэшлэгийг 2 удаа зохион байгуулж нутгийн иргэдэд сурталчилан ажилласан нь олны талархал хүлээсэн бүтээлч ажил боллоо.



Соёлын төвийн дэргэдхи дугуйлангийн сурагчид Улс, Аймгийн уралдаанд



Улс, аймагт “Уран эгшиг “ өсвөрийн хөгжимчдийн уралдаан, МУ-ын СТА улсын ерөөлч магтаалч Цэрэнчимэдийн нэрэмжит улсын уралдаанд нийт 8 сурагч оролцож хөгжмийн гоцлол, исгэрээний төрлөөр хүрэл медаль, тусгай шагнал тус тус хүртсэн. Дундговь аймаг Шилдэг аймгаар шалгарахад хувь нэмрээ оруулан ажилласан.

МУ-ын гавьяат жүжигчин алдарт дууч Дорждавгын нэрэмжит бүсийн наадамд дугуйлангийн сурагчдаас нийт 30 сурагч оролцож, морин хуур, уртын дууны хамтлаг гоцлол, бүжгийн хамтлагууд шалгаран аймагт болсон 2-р шатны шалгаруулалтанд амжилттай оролцлоо. Уртын дууны гоцлол төрөлд сурагч М.Батирээдүй тусгай байрыг эзлэв.



Засгийн газрын үндэсний хөтөлбөр, Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн. Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтыг дурдвал:

1. СОЁЛЫН БАРИМТАТ ӨВИЙГ ХАМГААЛАХ “ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-86,6%
2. Монгол уран бүтээл үндэсний хөтөлбөр-83,0 %
3. Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр-87,5 %

Хөтөлбөрийн хэрэгжилт – 85,7 хувийн хэрэгжилттэй

1. Дундговь Дуу хуур Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт **93 % хувь**
2. Соёл урлагийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт-95 % тай. Аймгийн 2 хөтөлбөр **94 хувьтай** тус тус амжилттай хэрэгжиж байна.

Аймаг, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хяналт тавин ажилласаны үр дүнд хэрэгжилт 81,65 хувийн биелэлттэй ажиллаж байна

Хүүхдийн төлөөх сайн үйлсийн аян

Монголын ахмадын баярыг угтаж сумын нийт ахмадууд, Соёлын ажилтан нар санаачилан зохион байгуулсан Хүүхдийн төлөөх сайн үйлсийн " Сэтгэлийн өглөг " хандивийн тоглолт амжилттай сайхан боллоо.

Тус тоглолтонд Соёлын төвийн дугуйлангийн сурагчид, Цэцэрлэгийн бяцхан сурагчид, Ардын авьяастанууд ая дуугаа өргөж 500,0 мян төгрөгний хандив оруулан ажиллаа.

Ахмадын баяр



Ахмадын баярт зориулсан Цагаан идээ боловсруулалт

, гар урлал, хүнсний ногоо, төрөл бүрийн хоолны үзэсгэлэн худалдаа, Хэний цай амттай вэ цайны өдөрлөг гэх мэт 8 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 30 ахмадыг 6 нэр төрлийн 70 гаруй бүтээл оролцлоо. Ахмадуудын бүтээлийг 1-3 байр эзлүүлж шагнаж урамшуулав.

Ахмадын дунд Шагайн харваан тэмцээн зохион байгуулахад нийт 18 харваачид оролцож Хишигжаргал, Адьяадулам, Ж.Пүрэв нар эхний байрыг эзлэв.

Ахмадын баярын хуралд нийт 97 ахмад оролцсон. Баяраар монголын ахмадын хүндэт тэмдгээр ахмад багш А.Энэбиш, Хүндэт өргөмжлөлөөр 1-р багийн малчин Батцоож, малын эмч Чүлүүн Аймгийн хүндэт тэмдгээр -1-р багийн малчин Түмэнжаргал, Ж.Пүрэв, Аймгийн жуух бичгээр ахмад малчин Сүрэн, С.Алтанцэцэг, Сумын жуух бичгээр ахмад малчин Ш.Адьяа, Д.Сумьяа тус тус шагнагдлаа. Мөн ахмадын хороо нь 80-90 хүртэлх насны 16 ахмадад хүндэтгэл үзүүлэлээ. “Алтан

хэлхээ” гурван үеийн уулзалт арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд ахмадын зүүн бүсийн урлагийн наадамд манай ахмадууд амжилттай оролцож бүжгийн төрлөөр хүрэл медаль, гоцлол дуу, хөгжмийн төрлөөр мөнгөн медаль тус тус хүртлээ.

нийт 60 гаруй хүүхэд оролцсон.



МУ-ын МСТА ахмад номын санч С.Нанжидын хөдөлмөр алдарыг тэмдэглэв.



Алдарт зохиолч С.Бүяннэмэхийн 115 жилийн ойн хүрээнд үохион байгуулагдаж буй МУ-ын СТА ахмад номын санч асан С.Нанжидын хөдөлмөрийн алдар тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд Уран жиргээ-2017 уран уншлагийн тэмцээнийг тэмцээнд нийт 83 хүүхэд оролцсоноос 2-5 насны ангилалд 1-р байранд Э.Маргад-Эрдэнэ, 2-р байранд А.Дашмаа, 3-р байранд Х.Саруулмонгол, тусгай байранд Э.Өнөрчимэг, Бага ангийн төрөлд 1-р байранд О.Отгонцэцэг, 2-р байранд М.Чүлүүнболор, 3-р байранд Мандахнаран, Дунд ангийн төрөлд 1-р

байранд Н.Цэцэгжаргал, 2-р байранд Ц.Уянга, 3-р байранд О.Дэжиллхам, тусгай байранд О.Мөнхцэцэг нар тус тус амжилттай оролцсон. Мөн нэрэмжит номын болон киноны дүр бүтээх тоглолт, тэмцээнийг хэсэг хороолол, албан байгууллагуудын дунд амжилттай зохион байгуулж 1-р байранд Баян хороолол, 2-р байранд Соёлын төв, 3-р байранд Хүүхдийн цэцэрлэгийн хамт олон орсон.

Соёлын төв нь 2017 онд соёл урлаг уран бүтээл -5, түүх соёлын биет өвийн талаар 5, утга соёлын өвийн талаар 6, уралдаан тэмцээн, бусад арга хэмжээ 31 нийт 97 ажил зохион байгуулж 5211 хүн хамрагдсан байна.

